




Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачлага

Монголын Бохир Ноолуурын Экспортыг Хориглосноос Үүдэх Үр Дагавар



1999 оны наймдугаар сар

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаас санхүүжүүлэв

Гарчиг

• Монголын Бохир Ноолуурын Экспортыг Хориглосноос Үүдэх Үр Дагавар	
Ерөнхий байдал	1
Эдийн засгийн үр дагавар	2
Улс төрийн үр дагавар	3
Олон улсын үр дагавар	3
Бусад бодлогууд: Дүн шинжилгээ	4
Бусад бодлогууд: Ач тус	7
Дүгнэлт	8
• Арга барил	9
Дэлхийн хялбар загвар	10
1-р диаграмм	13
Загварын хувилбарууд	15
Хүснэгтүүд: 1-9	
Хавсралт хүснэгт: 1-4	

Асуулт, санал хүсэлтээ дараах хаягаар ирүүлнэ үү:

Факс: 976-1-320-739

E-mail: shahn@gobi.initiative.org.mn



АНУ-ын Олон улсын хөгжлийн Агентлагаас Монгол улсын говийн бүсийн эдийн засгийг түлхүү хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгоор Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх Санаачилгыг байгуулж ажлаа эхлээд байна. Санаачилгын үйл ажиллагааг Мерси Кор Интернейшнл удирдан зохион байгуулж, Ассошейтс ин Рурал Девелопмент Инк, Пакт, Ланд О Лейкс хэмээх гурван байгууллага дэмжлэг үзүүлж байгаа юм.

Зах зээлээр зохицуулагдсан эдийн засгийн өсөлт хөгжлийг түргэсгэн цаашид тогтвортой үргэлжлүүлэхүйц цогцолбор арга хэмжээ авахад нь говийнхонд туслах явдал бол тус Санаачилгын зорилго юм. Хөдөөгийн аж ахуйн байгууллага, олон нийт, орон нутгийн удирдлага хүчээ нэгтгэн нэг дор хамтран ажиллаж эцсийн үр дүнд хүрдгээрээ манай ажил онцлог чанартай.

Энэ зорилгодоо хүрэхийн тулд Санаачилгаас мэдээллийн систем, орон нутгийн удирдлага ба бодлого, бизнесийн хөгжил гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдсэн хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Мэдээллийн систем

Эдийн засгийн болон бизнесийн мэдээлэлтэй байх хэрэгцээг хангах үүднээс Монголын хөдөөд мэдээлэл боловсруулж тараах чадавхийг хүчтэй болгох зорилтыг тус Санаачилга энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд тавин ажиллаж байна. Мэдээ мэдээлэл бэлтгэж тараах чиглэлээр ажилладаг хувь хүн, байгууллагаас гадна мэдээлэл хэрэглэгчидтэй манай Мэдээллийн системийн баг ажилладаг юм.

Орон нутгийн удирдлага ба бодлого

Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Санаачилга нэгдүгээрт, говийн аймгуудын эдийн засгийн хөгжлийг урт хугацааны туршид дэмжих явдалд орон нутгийн төр, захиргааны байгууллага болон хувийн хэвшлийнхний хамтын ажиллагааг чиглүүлэх, хоёрдугаарт, төрөөс хэрэгжүүлж буй бодлогод хөдөөгийн эдийн засгийн хөгжилд хэрэгцээ шаардлагатай байгаа бүхнийг илүү сайн тусгах явдлыг хангах талаар эрэлхийлж ажиллаж байна. Орон нутгийн удирдлагын баг нь тус улсын төв орон нутгийн удирдах байгууллага, албан тушаалтан болон бизнесийн хүрээнийхэн, олон нийтийн төлөөллийн байгууллагуудтай ажиллаж байна.

Бизнесийн хөгжил

Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Санаачилга эдийн засгийн өсөлт, хөгжлийг зах зээлээр зохицуулагдсан, тогтвортой болгоход үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Уламжлалт болон шинэ төрлийн аж ахуйн байгууллагуудын үр бүтээлч, ашигт ажиллагааг сайжруулахын тулд урьд нь ажиллаж байсан, шинээр байгуулагдаж буй аж ахуйн нэгж, бизнесийн холбоо, хоршоолол болон малчидтай Бизнесийн хөгжлийн баг ажиллаж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд дараах хүмүүстэй холбоо барина уу:

*Стефен Д. Вэнс, Санаачилгын удирдагч
Лэйтон Крофт, Мэдээллийн хөтөлбөрийн захирал
Женнифер Л. Батз, Орон нутгийн удирдлагын хөтөлбөрийн захирал
Сюзан А. Хан, Бизнесийн хөгжлийн хөтөлбөрийн захирал*

Монголын Бохир Ноолуурын Экспортыг Хориглосноос Үүдэх Үр Дагавар

Говийн бүсийн эдийн засгийн хөгжлийн Санаачлагын зөвлөх Вернон Ронинген

Ерөнхий байдал

Ноолуур нь Монголын нэгэн чухал бүтээгдэхүүн билээ. Энэ нь малчдад орлогын чухал эх үүсвэр болж өгч, хөдөө аж ахуйн дотоодын нийт бүтээгдэхүүний 18 хувийг эзэлж байна. Боловсруулагчид ноолуур боловсруулан, эцсийн бүтээгдэхүүн болох угас, хувцас үйлдвэрлэн, гадаадын дээд зэрэглэлийн хувцасны зах зээлд нийлүүлснээрээ бас төв суурин газарт орлогын эх үүсвэр бүрдүүлж байна. Ноолуур боловсруулах болон эцсийн бүтээгдэхүүн гаргадаг үйлдвэрүүд нь аж үйлдвэрийн дотоодын нийт бүтээгдэхүүний 37 хувийг үйлдвэрлэж байгаа ажээ. Ноолуур боловсруулалтын дээрх гурван үе шат (анхан шатны боловсруулалт хийх, зэрэх, бэлэн бүтээгдэхүүн) нь нийлээд Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 15 хувийг эзэлдэг байна.

Дэлхийд хамгийн том ноолуур үйлдвэрлэгч Хятад улс жилдээ 10 мянган тонн ноолуур бэлтгэж дэлхийн зах зээлийн 67 хувийг хангаж байна. Монгол улс хоёрдахь том бэлтгэн нийлүүлэгчийн хувьд 3 мянган тонн буюу дэлхийн ноолуурын зах зээлийн 21 хувийг бэлтгэж байна. 1990-ээд оны эхээр Хятадын эдийн засгийн төвлөрөл задарч чанар муутай ноолуур зах зээл дээр хэт их нийлүүлэгдэхэд дэлхийн ноолуурын зах зээл дээрх Хятадын давамгайлал илт мэдрэгдсэн билээ. 1989 онд дэлхийн зах зээл дээр бохир ноолуурын үнэ килограмм нь 60 ам. доллар байсан бол 1993 онд 14 ам. доллар болж унасан юм.

1994 онд бохир ноолуурын үнэ дахин өсөхөд Монголын ноолуур боловсруулагчид өөрсдийгөө ноолуураар хангах талаар санаа зовж эхэлсэн ба улмаар Монголын Засгийн Газар бохир ноолуур экспортлоход хориг тавижээ. 1995 онд дэлхийн зах зээл дээр бохир ноолуурын үнэ кг нь 40 ам. долларт хүрсэн. Хориг тавьсан 1994-1996 оны хооронд үндэсний үйлдвэрүүд ашигтай ажиллаж, гадаадын хөрөнгө оруулалтаар ноолуурын үйлдвэрүүдийн тоо ч өсчээ. 1996 онд Азийн Хөгжлийн Банк болон олон улсын зээл тусламжийн бусад байгууллагуудын шахалтаар Монголын Засгийн Газар хоригоо цуцлан экспортыг дахин чөлөөлсөн байна. Ноолуурын экспортыг хориглохыг байхад Дэлхийн худалдааны Байгууллагад Монгол улс гишүүнээр элч ороход бэрхшээлтэй байсан. Улмаар 1997 онд хоригийг цуцлан оронд нь экспортын 30 хувийн татвар тогтоожээ. Түүнээс хойш дэлхийн зах зээл дээрх бохир ноолуурын үнэ унах хандлагатай болж 1998 онд килограмм нь 15 ам. доллар болтлоо буурсан байна.

1999 оны эхнээс ноолуурын экспортод дахин хориг тавиулах кампани өрнөсөн ба энэ асуудал Их Хурлаар хэлэлцэгдэн цөөхөн санал дутсанаар батлагдаагүй байна. Хятад руу бохир ноолуур улам ихээр экспортлох болж улмаар үйлдвэрлэлээ явуулах түүхий эдээс нь салгаж буйд хориг тавихыг дэмжиж буй боловсруулагчид санаа зовж эхэлсэн ажээ. 1999 оны эхний хагас жилийн байдлаар 600 тонн ноолуур хил давсан тухай албан ёсны мэдээ байгаа бол бас 600 тонн ноолуур 30 хувийн татваргүйгээр, хууль бусаар хил давсан гэж олон хүн үзэж байгаа юм байна. Хятад худалдаачид ноолуурын үнийг зохиомлоор өсгөхөд Монголын үйлдвэрлэгчид ноолуур худалдаж авахаа больж зарим нь бүтэн жилийнхээ үйлдвэрлэлийг явуулах хангалттай нөөцгүй үлджээ. Монголын ноолуур боловсруулагчид Монгол улсад бэлтгэгдэж байгаа 3 мянган тонн ноолуурыг боловсруулах хүчин чадалтай боловч энэ жил гэхэд л бүх ноолуурын 40 хүртэл хувь нь Хятадруу экспортлогдсон байна. Урьдын хоригтой байх үеийн ашиг орлого үйлдвэрлэгчдэд болон эцсийн дүнд малчдад эргэж ирнэ гэж хориг тавихыг дэмжигчид үзэж байгаа юм байна.


Экспортын татвар буюу экспортын хориг тавих, экспортын бүтээгдэхүүнд тооны хязгаарлалт хийх зэрэг худалдааны бодлого нь ерөнхийдөө экспортыг зогсоох арга хэмжээ байж чаддаг. Үүний оронд дотоодын үйлдвэрүүд дотоодын түүхий эдээ худалдаж авахдаа гадаадын худалдан авагчидтай өрсөлдөхөд нь дэмжихийн тулд татаас өгөх, татвар багасгах зэрэг аргыг хэрэглэж бас болдог. Хэрэв ноолуураа Монголд боловсруулан үйлдвэрлэл явуулах зорилго тавьж байгаа бол, экспортыг хориглох нь авч болох арга хэмжээнүүдийн дотор хамгийн эцсийнх нь юм. Бохир ноолуурт ногдуулсан 30 хувийн экспортын татвар нь экспорт бууруулахад зарим талаар үнэхээр нөлөөлж байна. Хэрэв үндэсний үйлдвэрүүд Монголын

Хятадын наймаачидтай адил үнэ төлж чадахгүй байгаа бол Монголын Засгийн Газар үйлдвэрүүдээ дэмжин түүхий эд худалдан авахад нь шууд ба шууд бусаар (жишээ нь, үйлдвэрлэгчдэд бага хүүтэй зээл олгох гэх мэт) татаас үзүүлж болох талтай. Мөн Засгийн Газар үйлдвэрлэгчдийн зардлыг багасгахын тулд татвараас хэсэг хугацаанд чөлөөлж, Хятадуудтай өрсөлдөх чадварыг нь дээшлүүлж болох юм. Ноолуураар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг боловсруулсан ноолуур ихээр авахыг нь урамшуулахын тулд мөн адил арга хэмжээ авч болно. Ингэсэн тохиолдолд тэдэнд борлуулахын тулд боловсруулагчид илүү их бохир ноолуур худалдан авах шаардлагатай болно. Нөгөөтэйгүүр Засгийн Газраас ноолуур, ноолууран бүтээгдэхүүний арилжааг зохицуулах асуудлыг чөлөөт зах зээлд үлдээж, боловсруулагчдыг Хятадын худалдан авагчидтай өрсөлдөхөөс өөр аргагүй байдалд хүргэж бас болно. Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад ноолуурын экспортыг хориглох талаар эргэцүүлэхэд нь тус дөхөм үзүүлэх зорилгоор хоригийн үр дагавар, түүний дотор урьд өмнө нь авч үздэггүй байсан зарим үр дагаварт энэ илтгэл дүн шинжилгээ хийв. Ноолуур нийлүүлэлтийн асуудлаарх бодлогын өөр хувилбарууд түүний дотор Монголоос өөрөөс нь төдийлөн хамаарахгүй эдийн засгийн зарим хандлагыг энд бас авч үзлээ. Эцэст нь ноолуурын аж үйлдвэрт үр ашигтай байж болох зарим бодлого, хөтөлбөрийг ерөнхийд нь хэлэлцэв.

Бохир ноолуурын экспортыг хорьсноос үүдэх үр дагавар

Эдийн засгийн үр дагавар

1999 онд бохир ноолуурын экспортод хориг тавибал Монголын үйлдвэрлэгч, боловсруулагчдын ноолуур авах зардал нь багасан, ашиг нь нэмэгдэж олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадвар нь сайжирна. Ноолуур боловсруулагчдын ашиг алс хэтдээ 26 хувиар буюу 17 сая ам. доллараар өсөх боломжтой. Тэгвэл малчдын орлого 51 хувиар буюу 31 сая ам. доллараар буурна. Хориг дангаараа гадаадын зах зээл дээрх бохир ноолуурын үнийг хэтдээ килограмм тутамд 4 ам.доллараар өсгөх боловч Монголын малчдад энэ өсөлт мэдрэгдэхгүй. Хориг тавьснаар Монголын боловсруулагчдаас гадна Хятадын малчдын орлого 27 хувиар буюу 55 сая ам. доллараар нэмэгдэх юм (1 дүгээр хүснэгт). Ноолуур боловсруулагчдын орлогоос авах 1-2 сая ам. долларын татвар нь алдаж буй 8 сая ам. долларын экспортын татварын орлогыг нөхөж чадахгүй учраас Монголын Засгийн Газар 7 сая орчим ам. долларын татварын орлогоо алдах юм.



Одоогийн экспортын татвар төлүүлэхэд учирч буй бэрхшээлээс үзэхэд экспортын хоригийг амьдралд хэрэгжүүлэхэд бас бэрхшээлтэй байх төлөвтэй. Хоригоос шалтгаалан ноолуурын үнэ лотооддоо килограмм нь 10 ам. доллар болтлоо буурч Хятадад килограмм нь 24 ам.доллар хүртэл өсөж болох учраас хоригоос зайлсхийсний ашиг өндөр байх болно. Нэг килограммаас авч буй 4 ам. долларын татвар төлөхөөс зайлсхийж хууль бусаар Хятад руу экспортлож байгаа бол үнийн зөрөө 3 дахин илүү болох үед хоригийг хэрэгжүүлэхэд маш бэрхшээлтэй болно.

Урьд нь бохир ба боловсруулсан ноолуурын үнэ хэлбэлзэж, 1993-1995 оны ноолуурын хоригийн үед гурав дахин ихсэж байсан ч хоригоос болж үнэ өсөж байсныг харуулах баримт алга байна. Дэлхийн зах зээл дээрх үнийг ингэж гурав дахин нэмэгдүүлсэн хандлага, үйл явдал Монголоос гаднах зах зээл дээр болж байгаа нь лавтай. Учир нь Монгол улс дэлхийн ноолуурын зөвхөн 20 хувийг нийлүүлдэг. Тухайлбал, 1993-1995 онд дэлхийн эдийн засаг түргэн өссөн бөгөөд энэ нь ноолуурын эрэлт хэрэгцээг дэлхий нийтийн хэмжээнд хүчтэй өсгөсөн байж магадгүй юм.

Улс төрийн үр дагавар

Монгол улсын хүн амын 40 хувийг бүрдүүлдэг малчид орлогыг нь эрс багасгах учраас уг хоригт дургүйцэх бөгөөд эхний хориг тогтоосон үеийнх шиг асуудлыг улс төрийн өнгө аястайгаар хүлээж авч магадгүй юм. Бусад улсын жишгээс харахад нийгмийн аливаа нэг бүлэглэлд сөрөг нөлөөтэй бодлого улс төрийн чухал үр дагавартай байдаг. АНУ-д ерөнхийлэгч Картер хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортод хориг тавьсан нь Америкийн фермерүүдийн эгдүүцлийг төрүүлж улмаар дараагийн сонгуульд ялагдах нэг шалтгаан нь болсон юм. Экспорт худалдааны хориг арга хэмжээ нь хүний нүдэнд илт байдаг учраас фермерүүд бүх бэрхшээлээ тухайн хоригтой холбон тайлбарлаж байсан нь асуудлын зөвхөн нэг тал юм. Одоо "хэзээ ч хориг бүү тогтоо" гэсэн уриа фермерийн бүлгийнхний улс төрийн гол уриа болоод байгаа ажээ.

Олон улсын үр дагавар

Экспортод хориг тогтоох нь Дэлхийн худалдааны Байгууллага болон Монголд төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр зэхэж буй олон улсын байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаанд ноцтой бэрхшээл учруулж болзошгүй. Эдгээр байгууллага зохих ёсны бодлого, хуулиар зохицуулагдсан чөлөөт зах зээл хөгжүүлэх явдлыг хүчтэй дэмждэг. Тэд экспортын хориг гэхчлэн зах зээлийг шууд хянах арга барилыг эрс эсэргүүцдэг. Татвар, татаасын бодлого нь зах зээлийн үнийн механизмаас зайлсхийлгүй харин түүнийг хэрэглэж бодлогын чанартай зорилтоо хэрэгжүүлэх боломж олгодог учраас тэд уг бодлогыг илүүд үздэг. Түүнээс гадна Дэлхийн худалдааны Байгууллагын аль нэг гишүүн орны ноолуур боловсруулагч эсвэл өөр үйлдвэрлэгчид хохирол учруулсан тохиолдолд Дэлхийн худалдааны Байгууллагад гомдол ирж улмаар Монгол улс худалдааны нөхөн төлөөс төлөхөд хүрч болзошгүй.

Монголын бохир ноолуурын экспортод шууд нөлөөлөх бусад бодлогууд

Экспортын татвар хураах ажлыг сайжруулах

Бохир ноолуурын экспортын одоогийн татвар нь экспорт багасгахад үнэхээр нөлөөлж байна. Гэвч Хятад руу гаргаж байгаа ноолуурын 50 хувийг хууль бусаар татваргүй гаргаж байгаа тооцоо байна. Хэрэв ноолуурын бүх экспортоос татвар хурааж чадвал Хятад руу гарах экспортын хэмжээ 33 хувиар буурч магадгүй. Тэгвэл ноолуур бэлтгэлийн үнэ 14 хувиар буурч боловсруулагчийн ашиг 6 хувиар нэмэгдэх ажээ. Ноолуурын салбараас улсад орох татварын орлогын хэмжээ бас 4 хувь буюу 1 сая ам. доллараар өсөх юм байна. Мэдээж хэрэг, Монголын малчдын орлого хэтдээ 16 хувиар буурч, Хятадын малчдын орлого харин 5 хувиар нэмэгдэж экспортод хориг тавьсантай төстэй үр нөлөөтэй байж болох боловч цар хүрээгээрээ гуравдугаарт орж байгаа юм (2 дугаар хүснэгтийг үз).

Хятадтай урт хилээр залгадаг, татвараас зайлсхийснээс олох ашиг өндөр байдаг нь хууль бусаар ноолуур хил давуулах явдлыг ашигтай, татвар цуглуулах ажлыг бэрхшээлтэй болгож, авилгалыг өөгшүүдсэн хүчин зүйл болоод байна. Гаалийнханд зориулсан сургалт явуулан тэдэнд техникийн туслалцаа үзүүлвэл экспортын татвар хураах ажлыг сайжруулахад тустай байж магад. Ноолуур хулгайгаар хил давуулах болон хилийн бусад маргаантай асуудлаар Хятадтай урт хугацааны хамтын ажиллагааг эхэлж болно. Монгол улс хил дээр хууль тогтоомж хэрэгжүүлэх асуудлаар Хятадтай хамтарч ажиллах явдлыг Хятад Дэлхийн худалдааны Байгууллагад элсэх гэрээнд нь эсвэл Монгол-Хятадын тусгай хэлэлцээрт бусад орны тусламжтайгаар тусгаж болох юм. Хятадын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид Монголын урт ноолуур авах сонирхолтой, түүнд илүү үнэ төлөхөд бэлэн байдаг нь илэрхий. Иймд Монголын ноолуурын экспорт нь Хятад Монголын хил дээр экспортын татвар хураагдсан тохиолдолд л үргэлжлэх боломжтой гэсэн нөхцөл бүхий хэлцэлд хүрвэл энэ нь хууль бусаар хил давуулах явдлаас урьдчилан сэргийлэх асуудлаар Хятадын тал хамтарч ажиллахад нь дэмжлэг болж магад.

Ноолуурын чанарыг сайжруулах

Ноолууран бүтээгдэхүүн чанар, загвараасаа шалтгаалан янз бүрийн үнэтэй байдаг билээ. Боловсруулсан ноолуур, ноолууран бүтээгдэхүүний чанар өндөр байвал малчид, боловсруулагчдын аль алинд нь дэлхийн зах зээл дээрээс унах ашиг өндөр байх ёстой. Ноолуурын чанарыг алс хэтдээ 10 хувиар сайжруулах хөтөлбөр, үйл ажиллагаа малчид ба боловсруулагчийн орлогыг 11 хувиар, үйлдвэрлэгчийн орлогыг 18 хувиар нэмэхээр байна (6 дугаар хүснэгтийг үз). Бохир ноолуурын экспортын хэмжээг зөвхөн 4 хувиар өсгөхөд л Монголын холбогдох бүх бүлгийнхний орлого өсөх хандлага ажиглагдаж байна. Монголын боловсруулагчдад тус болох гээд малчдаа хохироосон экспортын хориг нэвтрүүлэн зах зээлийг удирдах гэж оролдсоноос зах зээл дээрх давуу байдлаа ашиглан ажлын үзүүлэлтээ сайжруулж болох зах зээлийн стратегийн жишээ энэ болно. Ноолуурынхаа чанарыг сайжруулахын тулд Монгол улс үржлийн хөтөлбөр нэвтрүүлж, чанар муутай ноолууртай хөгшин ямаагаа заазлан, сайн чанарын ноолуур үйлдвэрлэх явдлыг урамшуулдаг маркетингийн хөтөлбөр нэвтрүүлж болох юм. Гадаадын зах зээлийн талаарх мэдээлэл сайн байвал боловсруулсан ноолуур, ноолууран бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн эцсийн хэрэглэгчдэд хүрч ажиллахад нь боловсруулагч, үйлдвэрлэгчдэд хэрэгтэй байх болно.

Одоо, ирээдүйн байдлын тухай мэдээлээ сайжруулах

Ихэнх орнууд хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүнийхээ одоо, ирээдүйн байдлын талаар мэдээллийн системтэй байдаг. Дотоод, гадаад зах зээлийн нөхцөл байдлаа байнга хянаж энэ талаарх мэдээлээ үйлдвэрлэгч, боловсруулагчдад нээлттэй байлгадаг байна. Дэлхийн ноолуурын зах зээлийн талаар мэдээллийн сан бүрлүүлж, хэрэглэж, эсвэл түүнд оролцох нь Монголын малчид, боловсруулагчдад тустай байж болох юм. Ирээдүйд үнэ ямар байх талаар урьдчилсан мэдээлэлтэй байвал тэдэнд үйлдвэрлэлийнхээ талаар шийдвэр гаргахад нь хэрэгтэй. Одоохондоо зарим мэдээлэл хувь хүнд байгаа боловч мэдээлэл олон нийтэд хүртээлтэй байх нь зах зээл дээр бүгд шударга өрсөлдөх нөхцлийг хангах юм. Дэлхий нийтийн ноолуурын эрэлт хэрэгцээний одоо, ирээдүйн байдлын тухай мэдээлэл нь Монгол, Хятад

болон бусад ноолуур гаргадаг орнууд, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс хамтран ажиллахыг шаардаж байна.

Ноолууран бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ дэлхийн хэмжээнд нэмэгдэхэд ямар үр дагавар гарахыг үзүүлэхийн тулд дэлхийн эдийн засаг одоогийнхтойгоо харьцуулахад 1 хувиар өснө гэж тооцсон загвар гаргав (4 дүгээр хүснэгтийг үз). Мөн дэлхийд ноолууран бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нэмэгдэнэ гэж үзлээ. Уг загварын дагуу Монголын малчид, боловсруулагч, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн урт хугацааны ашиг орлого 11%, 18%, 30%-иар тус тус нэмэгдэх тооцоо гарч байна. Дэлхийд ноолуурын эрэлт хэрэгцээ хэзээ, хэрхэн нэмэгдэхийг мэдэж байх нь хэр зэрэг чухлыг ийм дүн шинжилгээ харуулж байгаа бөгөөд Монголын боловсруулагч, үйлдвэрлэгчид ийм боломжийг аль болохоор сайн ашиглаж, гадаадын өрсөлдөгчдөд алдахгүйн тулд бэлтгэлтэй байх боломж олгоно. Хэрэв монголчууд одоо, ирээдүйн байдлын талаарх мэдээллийн даруухан ч гэсэн ямар нэг хөтөлбөрийг бие даасан агентлаг эсвэл аль нэг их сургууль дээр байгуулбал Монгол улсад хэрэгтэй байх билээ. Ноолуур болон Монгол улсад чухал ач холбогдолтой хөдөө аж ахуйн бусад бүтээгдэхүүний талаар Монголын эдийн засагчид холбогдох тоо баримт, мэдээллийн бааз цуглуулж, энэ илтгэлд хийсний адилаар дүн шинжилгээ хийх нь бидний зорилт мөн.

Эдийн засгийн ерөнхий бодлого

Монгол Хятадын эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал хоёр орны худалдаанд нөлөөлөх тул үүнд бас анхаарах нь чухал. Ерээд оны эхээр Монголд инфляци хурдацтай өсөж байхад, Хятадад энэ нь харьцангуй доогуур байсан нь Хятадын худалдан авагчдад Монголын наймаачдыг бодвол давуу тал бүрэлдүүлж өгсөн байж болох талтай. Инфляци өндөр нөхцөлд ноолуур борлуулах хатуу үнэ тогтоосон гэрээ эсвэл аман хэлцэл, мөнгөн гүйлгээ хийж бараа солилцох асуудал нэлээд төвөгтэй байдаг. Инфляцийг багасгаж, дор барих талаарх Монголын эдийн засгийн бодлого Монголын эдийн засгийн бусад бүх салбарт түүний дотор ноолуурын салбарт ашиг тустай.

Өөр нэг жишээ нь энэ жил Хятадууд ихээхэн хэмжээгээр Монголын ноолуур худалдан авч байгаа нь Хятадын мөнгөний ханшийг багасгах тухай цуурхалтай зарим талаар холбоотой байж болох юм. Санхүүгийн мэдээнээс үзвэл дэлхийн зах зээл дээр Азийн бусад экспортлогчидтай харьцуулахад Хятадын экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар буурсан учир Хятадын мөнгөний ханш улам бүр унаж болзошгүй байна. Хэрэв энэ намар Хятадын мөнгөний томоохон ханш уналт болвол Хятадын худалдан авагчдад Монголын ноолуур илүү үнэтэй болж, ирэх хэдэн жил зах зээлийн нэлээд хэсгийг Монголын боловсруулагчдад үлдээх болно. Гэвч Хятадын ханш уналт Монголд бас муу нөлөөтэй байж болохоор байна. Хятадын мөнгөний ханш 20 хувиар унана гэж тооцоолж үзэхэд Монголын ноолуурын экспорт 6 хувиар буурч, малчдын орлого 5 хувиар, боловсруулагчдийн орлого 3 хувиар тус тус буурч магадгүй байна (5 дугаар хүснэгтийг үз). Монголын эдийн засгийн менежмент, түүний дотор худалдааны гол том түншүүдийнхээ бодлогын өөрчлөлтөөс үүсэх үр дагаврын талаар авах арга хэмжээ нь тэдгээр түншийнхээ макро эдийн засгийн талаар сайн мэдлэгтэй байхыг шаарддаг. Нэг оронд мөнгөний ханш буурснаас болж Монгол улсын худалдаанд үр дагавар нь мэдрэгдэх явдал Монголын хувьд аргагүй бэрхшээлтэй хэдий ч үүнийг урьдчилан харж чадвал сөрөг нөлөөллийг нь бололцоотой хамгийн дор түвшинд байлгаж чадах юм.

Ноолуурын худалдаанд дахь Хятадуудын шударга бус үйл ажиллагааг зогсоох

Хятадын ноолуур боловсруулагч үйлдвэрүүд нь Засгийн Газраасаа бага хүүтэй зээлийн татаас, үйлдвэрлэлээ дэмжсэн шууд татаас эсвэл Хятадын аж үйлдвэрийн салбарын дотоод татаас авсан байдаг хэмээн олон хүн үзэж байна. Хятадын системд татаас ямар байдгийг хэлэхэд бэрх ч хэрэв Дэлхийн худалдааны Байгууллагад гишүүнээр элсэх Хятадын өргөдлийг хүлээж авбал уг байгууллага нь ийм татаасын тухай баримт олдсон цагт гомдлоо гаргах эрх бүхий байгууллага байх юм. Хятадын ноолуур боловсруулагч үйлдвэрүүддээ 10 хувийн татаас өгч байсан гэж үзээд түүнийг үгүй болгоход гарах үр дагаврын тооцоо хийж үзсэн (7 дугаар хүснэгтийг үз). Монголын хувьд энэ нь холимог үр дагавартай гэж хэлж болно, тухайлбал ноолуур боловсруулагчдын ашиг орлого 6%-иар нэмэгдэх боловч малчид, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн ашиг 1%-иар буурах хандлага харагдлаа. Тэгэхээр Хятадын

татаасын талаарх нотлох баримт олдож түүнийг нь олон улсын шахалтаар устгасан ч Монголын ноолуурын бүх салбарт ашиг гарахгүй байна. Хятадын ноолуур боловсруулагчид татаас авснаар эцсийн дүнд Монголын малчид ба ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид бас хожиж байгаагаас үзвэл аливаа бодлого хэрхэн олон талын үр дагавартай байж болдгийг энэ жилээ үзүүлж байна.

Бохир ноолуурын экспортын татварыг үгүй болгож ноолуурын зах зээлийг бүрэн чөлөөлөх

Монгол улс экспортын татвараа аажмаар үгүй болгон ноолуурын экспортын зах зээлээ чөлөөлөх бодлого баримталж болох юм. ДХБ-д гишүүнээр элсэх хэлцэлд хүрэхэд ийм шаардлага аяндаа тавигдана. 10 жилийн дотор буюу 2007 он гэхэд экспортын татварыг бүрэн устгах тухай зөвшилцөлд ДХБ-д элсэх гэрээ хийх үеэр хүрсэн байна гэж бодоод бохир ноолуурын экспортын татварыг аажмаар устгана гэж тооцоолон загвар гаргаж үзэв. Ингэснээр малчдын орлого 16 хувиар нэмэгдэн, боловсруулагчдийн орлого харин 5 хувиар буурч байв (3 дугаар хүснэгтийг үз). Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд онцын өөрчлөлт гарахааргүй байна. Улсад ноолуурын салбараас орох татварын орлого харин хэтдээ 7 хувь буюу 2 сая ам. доллараар буурах үзүүллэлт гарч байв.

Монголын сүлжмэл болон бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарыг өрсөлдөөнөөр өргөжүүлэх явдлыг дэмжих

Татварын бодлого, маркетингийн хөтөлбөрүүд эсвэл бусад үр бүтээлтэй арга замаар Монголын сүлжмэл болон бэлэн хувцасны үйлдвэрлэлийн өргөжилтийг дэмжвэл тус улс ноолуурын салбараас илүү олон ажлын байр, орлогын эх үүсвэртэй болох боломжтой. Ноолууран бүтээгдэхүүн жин, овор багатай тул тээврийн зардал нь бага, тиймээс дэлхийн зах зээлд бага зардлаар хүрэх боломжтой. Энэ салбар жилд 18 хувиар өрсөлдөж өргөснө гэж тооцоолон загвар гаргаж үзсэн. Нэлээд сонирхолтой үр дүн гарч байна. Малчид, ноолуур боловсруулагчид ба ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн ашиг орлого алс хэтдээ 7%, 12%, 155%-иар тус тус бүр нэмэгдэхээр гарч байна. (8 дугаар хүснэгтийг үз). Өрсөлдөж өргөсөх гэдэг нь Монголын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид Хятад болон бусад оронтой өрсөлдөн тэдний эзлэж байсан зах зээлийн заримыг өөрийн болгоно гэсэн үг юм. Бохир ноолуурын экспортын хэмжээ өөрчлөгдөөгүй ба ноолууран бүтээгдэхүүний экспортын хэмжээ хоёр дахин, экспортын үнэ нь 181 хувиар өсч, дотооддоо боловсруулсан ноолуурыг улам бүр бэлэн хувцасны болон сүлжмэлийн үйлдвэрлэлд ашиглах болсон тул боловсруулсан ноолуурын экспорт 51 хувиар буурч байна. Засгийн Газрын татварын орлого 19 хувиар нэмэгдэж энэ нь голчлон ноолуур боловсруулагч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс гарах ажээ. Өрсөлдөж өргөсөх, нэмүү өртөг шингээсэн дамжлага үүсгэн бүгдээр ашигтай ажиллах бодлогыг нэг салбарт тусалж нөгөөг хохироосон бодлоготой харьцуулан тус загвар харуулж байна.

Бодлого шийдвэрийн хувилбар болон эдийн засгийн загварыг хооронд нь харьцуулах

Бодлогын хувилбар болон эдийн засгийн загваруудыг Монголын эдийн засгийн орлогод алсын ирээдүйдээ өөрчлөлт оруулах үүднээс нь харгалзан үзэж ойролцоогоор харьцуулах боломжтой (9 дүгээр хүснэгтийг үз). Монгол улсын орлогыг алс хэтдээ нэмж байгаа бодлогын болон эдийн засгийн эерэг загварт багтах зүйлүүдэд дэлхийн эдийн засгийн өсөлт, гадаад дахь ноолуурын эрэлт хэрэгцээний өсөлтөөс унах ашгаас аль болох ихийг олж авах, дэлхийн бусад үйлдвэрлэгчдийн зах зээлийг эзэмдэхийн тулд Монголын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн амжилттай өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх, Монголын ноолуурын чанарыг боловсруулалтын бүх шатанд нь дээшлүүлэх явдал тус тус орж байна. Эдгээр загвараас харахад малчид, боловсруулагчид, хувцас үйлдвэрлэгчид бүгдэд нь ашигтай байхаар байгаа ба нэг нь ч нөгөөгийнхөө улмаас хохирохгүй байна. Харин экспортын хориг тогтоовол малчдын алдсан орлогыг боловсруулагчдын олсон ашгаас нөхөж чадахгүй учир нийтээрээ ашиг орлогоо алдахад хүргэж байна. Хятад улс мөнгөний ханшаа яльгүй бууруулахад ч Монголын ноолуурын аж үйлдвэрийн бүх салбарт сөрөг үр дагавартай байна.

Бусад бодлого, эдийн засгийн шийдлүүд орлогын хувьд үр дагавар нь төдийлөн их биш. Сөрөг үр дагавартай талд нь экспортын татварыг бүрэн төлүүлэх явдал орж байна (улсын санхүү,

боловсруулагчдын орлого нэмэгдсэн ч малчдын алдагдал ийм нэмэгдлээс хавьгүй илүү). Нөгөөтэйгүүр экспортын татвар болон Хятадын боловсруулагчдад цаанаас нь өгч байгаа гэх татаасыг устгасан ч Монгол улсад тусах ашиг нь бага байна.

Монголын Ноолуурын Салбарт Ач Тустай Бусад Бодлогууд

Зайны сургалтыг сайжруулах

Ноолуурын чанарын талаар малчдад мэдлэг олоход нь тусалж, ноолуурынхаа чанарыг хэрхэн дээшлүүлэх талаар тэдний хийж чадах арга хэрэгслийг зааж өгөх хэрэгтэй байна. Олон оронд телевиз, радио, сонин сэтгүүлийг энэ зорилгод ашигладаг. Зарим улсад төрийн байгууллагын (зайны сургалт хариуцсан) ажилтнууд хөдөө томилогдож малчид, боловсруулагчдад техникийн болон эдийн засгийн мэдээлэл өгөх үүрэгтэй ажилладаг байна. Иймэрхүү хөдөө орон нутагт тохирох үйл ажиллагаа хэрэгжүүлвэл Монголын малчдад тустай байх болно. Мөн ноолуур боловсруулагч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд зах зээлийн чиг хандлага, загвар, үнийн талаар байнга шинэчлэгдсэн мэдээллийг түгээх арга замыг боловсруулвал өөрчлөгдөж буй зах зээлийн нөхцөлд зохицуулан үйлдвэрлэлээ явуулж, өрсөлдөх чадвартай болгох билээ. Бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой товхимлыг энэ зорилгоор хэрэглэж болох ба Интернет зэрэг электрон мэдээллийн хэрэгслийг мэдээлэл шуурхай түгээхэд хэрэглэж байна. Гадаадын худалдан авагчидтай хамтран ажиллах нь ийм мэдээлэл авах бас нэг эх үүсвэр юм. Дэлхий нийттэй харьцуулахад Монголын ноолуур боловсруулагч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувийн жин бага учир айсуу өөрчлөлтийг урьдчилан мэдэж зах зээлийн өөрчлөгдөж буй нөхцөл байдалд зохицон хурдан өөрчлөгдөх чадвартай байх ёстой.

Монголын ноолуурын талаар сурталчилгаа хийх

Монголын ноолуурын чанарыг сайжруулахын хамт чанарын тухай сурталчилгаа хийхэд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Наяад оны үед Хятадын төвлөрсөн шийдвэр гаргадаг практик задрахад тэдний ноолуурын чанар муудаж, гадаад худалдаа нь багасан 1990 оны эхээр чанар муутай ноолуураар зах зээл дүүрсэн. Эдийн засгийн мэдээллийн Албаны (Economic Intelligence Unit) судалгаанаас үзвэл ноолуурын чанар ийнхүү муудсан нь дэлхийн ноолуурын зах зээлд ноцтой хохирол учруулжээ. Дэлхийн ноолууран эдтэл худалдан авагчид бусад сайн чанарын ноолуурын эх үүсвэр сонирхож эхэлсэн ба түүнд нь Монгол улс орж байв. Дэлхийн ноолуурын байнга хувьсан өөрчлөгдөж байдаг зах зээл дээр Монгол улс ноолуурын чанартай бүтээгдэхүүн тууштай үйлдвэрлэн сурталчилж байвал алсын ирээдүйдээ ашгийг нь хүртэх болно.

Ноолуурын чанарыг шинжлэн, чанарын баталгаа өгдөг бие даасан лабораторийг Монголд байгуулах талаар санал дэвшигдээд байна. Монгол ноолуурт чанарын тэмдгийн систем буй болгож ийм тэмдэггүй бүтээгдэхүүн Монголын сайн чанарын ноолуур биш гэдгийг дэлхий даяар мэддэг болгож болох юм.

Мөн ноолуур боловсруулагч, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид Интернетээр шууд маркетинг хийдэггүй юм гэхэд шууд сурталчилгаа хийх талаар бодолцвол зохино. Сүүлийн үед улам олон хэрэглэгчид Интернетээр чанартай бүтээгдэхүүн худалдан авч үгүй бол ийм бүтээгдэхүүний тухай мэдэж авч байна. Интернетийн вебсайт (website) нь бүтээгдэхүүнийхээ талаар дэлхий даяар сурталчлан мэдээлэх харьцангуй хямд төсөр арга юм. Интернетээр дамжуулан зарим ноолууран бүтээгдэхүүний захиалга авч, дараа нь илгээх арга хэмжээ бас авч болно.

Ноолуур боловсруулагчдын ноолуур бэлтгэлийг санхүүжүүлэх

Ноолуур бэлтгэлийн үеэр ноолуур худалдаж авах хангалттай санхүүжилт олддоггүй талаар зарим боловсруулагч өгүүлэл гаргасан байдаг. Хэрэв энэ нь үнэн бол Монголын ноолуур боловсруулагчид Монголоос ноолуур бэлтгэн авах тодорхой хэмжээний бэнчинтэй байгаа Хятадын худалдаачидтай харьцуулахад үнэхээр дорой байдалд байна. Банкны системтэй ийм бэрхшээлийг шийдэх талаар хамтран ажиллавал хэрэгтэй байж болох юм.

Ямаанаас гаралтай бусад бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлэх

Ноолуур малчдын хувьд орлогын чухал эх үүсвэр хэдий ч ямааны мах, арьс шир тодорхой өртгөөр борлогдож малчдын орлогод нэмэр болно. Монголын мах, арьс ширийг экспортлох стандартад хүргэх хөтөлбөрүүд авч хэрэгжүүлэх нь энд хэрэгтэй байх. Жишээ нь, Хятадад протеиний хэрэглээг хөхүүлэн дэмжих бодлого хэрэгжүүлж байгаа ба ямааны мах нь түүнийг агуулсан нэг бүтээгдэхүүн билээ. Одоогоор Хятадын импортлож байгаа махны стандартад Монголын махны чанар арай хүрээгүй гэж яригддаг байна. Тиймээс мах, арьс ширийг худалдааны стандартад хүргэх хөтөлбөр хэрэгтэй.

Бохир ноолуурын маркетинг ажиллагааг улам нээлттэй болгох

Ноолуурын маркетингийн талаар илүү нээлттэй бөгөөд зохион байгуулалттай журам нэвтрүүлж болох юм. Дуудлага худалдаа гэх мэт ил худалдааны үйл ажиллагаанд малчид буюу гэдний төлөөлөгчид Монгол Хятадын ноолуур худалдан авагчидтай нүүр тулан арилжаа хийвэл малчид хамгийн дээд үнээр ноолуураа борлуулж, бэлтгэгчид хамгийн сайн чанарын ноолуурыг хямдаар авах боломжтой болох юм. Гадаадын худалдан авагчдад нээлттэй, ноолуурын ил худалдаа нь экспортын татвар хэн төлөх талаар олж мэдэхэд нь улсын татвар цуглуулагчдад тус болох ёстой. Энэ нь экспортын татвар хураалтыг сайжруулах бас нэгэн алхам болно.

Дүгнэлт

Эцэст нь дүгнэж хэлэхэд Монгол улс нь боловсруулсан ноолуур ба ноолууран бүтээгдэхүүний экспортын дэлхийн зах зээлээс хамааралтай бөгөөд энэ нь зайлсхийх аргагүй хүчин зүйл. Ноолуур нь гадаадын зах зээл дээр тодорхой хэмжээгээр үнэлэгддэг учраас Монголын хувьд үндэсний баялаг болдог. Монголын ноолуурын салбарт нөлөөлөх эдийн засгийн үйл явдал, өөрчлөлт нь Монголын хяналтаас гадна тухайлбал гол өрсөлдөгч болох Хятадад болж байдаг. Яваандаа худалдаагаар дамжуулан Монголд сөрөг нөлөө үзүүлж байгаа өөр орнуудын бодлогын арга хэмжээг ДХБ-аар шийдвэрлүүлдэг болох бөгөөд ДХБ -нь анхнаасаа чухам ийм зорилгоор байгуулагдсан юм. Монгол улс дэлхийн зах зээлтэй холбогдсоноор Монголын ноолуурын бодлогод гарах өөрчлөлт тус зах зээлтэй уялдах ёстой болж байгаа ба энэ нь зарим үед дангаар хийсэн бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлэх боломжгүй болготол давамгайлах хандлагатай байдаг. Тиймээс бодлогын өөрчлөлт хийхээр төлөвлөж буй үедээ олон талаас нь нягт нямбай дүн шинжилгээ хийх хэрэгтэй.

Ноолууран бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн хэмжээ том учраас үйлдвэрлэлээ үр ашигтай, шуурхай явуулж, сайн маркетинг хийж чадвал дэлхийн ноолуурын зах зээлийн өндөр чанартай бүтээгдэхүүн худалдан авагч хэсгийг эзэмдэх өргөн бололцоо Монгол улсад байна. Энэ утгаараа Монгол ноолуур нь үнэхээр алтнаас үнэтэй байж болно. Өнгөрсөн хугацаанд дэлхийн ноолуурын зах зээл дээр үнэ нэлээд их хэлбэлзсэн. Гэвч дэлхийн зах зээлийн харьцангуй жижиг нийлүүлэгчийн хувьд Монгол улс зах зээл дээрх гарч буй хувиралтад бусдыг бодвол хурдан хариу өгөх чадвартай байх ёстой.

Эцсийн эцэст Монголчууд ноолуурынхаа салбарын ирээдүйг өөрсдөө тодорхойлно. Монголчуудын эдийн засгийн бодлогын сонголт, хөдөө аж ахуй болон мал аж ахуйгаа хөтлөх арга барил, маркетинг менежментийн чадавхи, дэлхийн зах зээлийн дээш доош хандлагын талаарх мэдлэг гэх мэт зүйлс Монголын ноолуурын салбарын хувь заяаг шийдэх юм. Энэхүү сорилтыг Монголчууд шийдвэрлэж чадна гэдэгт би хувьдаа итгэл төгс байна. Энэ судалгааны ажил маань Монголын ноолуурын салбарын талаар хэрэгжүүлэх бодлогыг цаашид хэлэлцэх явцад хувь нэмэр болох болов уу хэмээн найдаж байна.

Энэ илтгэлд хэрэглэсэн арга барилууд

Экспортын хоригийн үр дагаврыг үнэлэхийн тулд хоёр төрлийн ажиллагаа хийгдэв. Нэгдүгээрт, зохиогч олон хүнтэй уулзаж экспортын хоригийн талаар болон Монголын ноолуурын салбарын бэрхшээлтэй асуудлын талаар тэдний санаа бодлыг нь сонсов. Энэ асуудлаарх хүмүүсийн байр суурь өөр өөр байв. Эдгээр хүмүүсийн дотор Их Хурлын гишүүд байсан ба хоригийг зарим нь дэмжиж байхад бусад нь эсэргүүцэж байлаа. Түүнчлэн боловсруулагчид дотор ч энэ хоёр талын аль нэгийг барьсан хүн байна. Төрийн албаны зарим ажилтан хоригийн тухай энэ асуудал, хөдөө аж ахуйн экспорт, худалдаачдын талаар олон улсын нөхцөл байдалтай уялдуулан тайлбарлаж байлаа. Хоёрдугаарт, Монголын бохир ноолуурын экспортод хориг тависнаас үүдэх эдийн засгийн болзошгүй үр дагаврыг үнэлж тооцохын тулд дэлхийн ноолуурын зах зээлийг төлөөлсөн эдийн засгийн энгийн загвар буй болгов. Энэ загварыг бас бусад бодлогын хувилбаруудын үр дүнг тооцоход хэрэглэсэн болно.

Уулзаж ярилцсан хүмүүсийн байр суурийн тойм

Ноолуурын экспортод хориг тавихыг дэмжигчид 1994-1996 онд ийм хориг тавьж байсныг дурдаад тэр үед Монголын ноолуур боловсруулах бизнест гадаадын үлэмж хэмжээний хөрөнгө оруулалт орж ирснийг тэмдэглэж байлаа. Дахин хориг тавих нь ноолуур боловсруулах аж үйлдвэрийг сэргээнэ гэж тэд үзэж байна. Одоогийн (1999) оны байдлаар Монголын боловсруулагчид тус улсад авч буй бүх ноолуурыг боловсруулах хүчин чадалтай ч Хятадын худалдан авагчид (гаальд бүртгэгдсэнээр) 640 тонн ноолуур гаргаж, мөн тийм хэмжээний ноолуур хууль бусаар хил давснаас болоод түүхий эдийн хангалт дутуу байна. Гадагшаа ийнхүү гарч буй ноолуур нь энэ жил Монгол улс авахаар тооцож буй нийт 3000 тонн ноолуурын 40 хүртэл хувийг эзэлж байна. Гаргаж буй ноолуурыг нэгд нэггүй шалгах аас хориг тавьж хэрэгжүүлэх нь илүү амархан гэж дэмжигчид үзэж байгаа ажээ. Хориг тавьчихвал ноолуурыг нарийн шалгаж татвар төлүүлэх шаардлагагүй, ноолуур л байвал хураачих юм байна. Эцэст нь урьд өмнөх хоригийн үеийн туршлага дээрээ үндэслэн хоригийг дэмжигчид тайлбарлахдаа Монголын ноолуурын үнэ яваандаа нэмэгдэж, малчид шинэ хоригоос алдсан орлогоо нөхөөд цаана нь ашиг гаргана гэжээ.

Хятадын боловсруулагчид, тэдний Монгол дахь агентууд нь цаанаасаа татаас авдаг учраас Монголын боловсруулагчдад ноолуурын төлөө өрсөлдөхөд бэрхшээлтэй болж байгаа нь хориг нэвтрүүлэх нэг шалтгаан болохыг олонтаа дурдаж байна. Монголын боловсруулагчдыг түүхий эдээс нь салгаж, бизнесээс нь гаргах гэж Хятадууд далдуур хуйвалдаж байна хэмээн хэд хэдэн хүн үзэж байна. Яваандаа Хятад улс Монголын ноолуурын үнийг буцааж доошлуулан малчдын орлогыг ирээдүйдээ бас унагана гэж тэд үздэг ажээ. Хятадын үйлдвэрлэгчдийн ийм шударга бус бизнесийн үйл ажиллагааны нотолгоо болгож Монголын савхины аж үйлдвэрийн сүйрлийг энд дурдаж байна.

Ноолуурын экспортын хоригийг эсэргүүцэх шалтгаан ч хэд хэд байна. Урьд нь байсан хоригийг Азийн хөгжлийн Банк, Дэлхийн Банк болон бусад байгууллагууд эсэргүүцсэнээр энэ нь 1996 онд цуцлагдсан байна. 10 жилийн дараа зогсоох нөхцөлтэйгээр 30 хувийн экспортын татварыг 1997 онд нэвтрүүлжээ. Монгол улсын чөлөөт зах зээлд шилжих үед үйл ажиллагаа нь нэн чухал ач холбогдолтой хандивлагч байгууллагуудтай хамтран ажиллах явцад хоригийг дахин сэргээх нь улс төрийн ноцтой бэрхшээл үүсгэнэ гэж хоригийг эсэргүүцэгчид ярьж байна. Монгол улсын эдийн засгийг хурдтай өсгөхийн тулд хөгжлийн төслүүд, гадаадын хөрөнгө оруулалт хэрэгтэй байгаа билээ.

Хүн амын хамгийн ядуу хэсэг болох малчдын орлогыг бууруулах учраас зарим хүн хоригийг бас эсэргүүцэж байна. Малчид бас улс төрийн байр сууринаас хандаж, ноолуурын экспортыг дэмжиж байгаа хүмүүсийг ирэх сонгуульд лэмжихгүй байж магад. Олон хүн уг хоригийг хэрэгжүүлэх боломжгүйг цохон тэмдэглэж хэрэв хууль тогтоомжийн биелэлтийг сайжруулъя гэж байгаа бол улсын төсөвд орлого оруулж байгаагаар нь экспортын татвар төлүүлэх явдал дээрээ анхаарлаа төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Хоригийг тойрч гарч чадах хүмүүсийн олох ашиг орлого нь авилгалыг дэвэргэх болно гэж бас олон хүн санаа зовж байна.

Дэлхийн зах зээл дээр өрсөлдөхөд зайлшгүй шаардлагатай үйлдвэрлэлийн үр бүтээлт байдал, зах зээлийн ур чадвараа сайжруулахаас Монголын боловсруулагчид залуурч, хямдхан бохир ноолуур авч байх гэж энэ хоригийг санаачилсан гэж зарим нь үзэж байна. Малчид орлогоо аль болохоор дээшлүүлэхийн тулд аль өндөр үнэ санал болгосонд нь шууд зарах нь зүйтэй гэсэн байр суурийг нэлээд хүн хатуу баримталж байна.

Экспортын орлогын хоригийг дэмжигч, эсэргүүцэгч талууд гэхдээ өөр чухал асуудлаар санал нэг байна. Жишээлбэл, экспортын татвар төлүүлэх явдлыг бүрэн хэрэгжүүлж чадвал энэ нь Монгол улсад бохир ноолуурын нийлүүлэлтийг хэвийн байлгахад хавьгүй илүү үр нөлөөтэй байх ажээ. Сүүлийн арван жилийн дотор Монголын ноолуурын чанар муудаж байгааг олонх нь хэлж байлаа. Хятадуудын ноолуур худалдан авч буйн гол шалтгаан нь Монголын урт ноолуурыг өөрсдийн өндөр чанарын богино ноолууртай нийлүүлж ээрмэл утасны чанарыг сайжруулах явдал гэдгийг ихэнх нь мэдэж байна. Хятадуудын стратеги, татаас эсвэл үл ойшоох бодлогоос болж Монголын ноолуур худалдан авагчид тэдэнтэй нэг ижил түвшинд өрсөлдөж чадахгүй байгаа бөгөөд тиймээс одоогийн байдлаар экспортын татвар зэрэг бодлогын чанартай арга хэмжээ зайлшгүй шаардлагатай гэдэгт олон хүн санал нэг байна.

Монголын ноолуурын чанарыг сайжруулах хөтөлбөр байвал олонх нь дэмжихээр байна. "Хэт хөгшин ямааны" бэрхшээл байгааг хүмүүс дурдаж байлаа. Хөгшин малаас чанар муутай ноолуур гардаг. Малын өвчинтэй холбоотой асуудлууд, мөн Орос дахь махны зах зээл устсанаас болоод ямаа нядлах явдал эрс багассан байна. Хөгшин малын бүтээгдэхүүний зах зээл буй болгох талаар авсан аливаа арга хэмжээ автоматаар ноолуурын чанарыг сайжруулах арга хэмжээ болж хувирах юм. Түүнчлэн үржлийн хөтөлбөр яваандаа чанар сайжруулах юм гэж олон хүн ярьж байна.

Зарим боловсруулагчид өөрсдөө зах зээлээ олж, зарим нь наймаачдад найдаж байна. Малчид, боловсруулагчдад илүү сайн бололцоо олгосон сайн маркетингийн систем хөгжүүлж болно гэж хэд хэдэн хүн бодож байна. Хятад болон Монголын наймаачид ерөнхийдөө малчдыг ашиглаж байгаа тул үнэ хаялцуулах худалдаа, хоршооллоор дамжуулж худалдах зэрэг маркетингийн дэвшилтэт арга барил нэвтрүүлбэл хүн бүрт шударга байх болно гэсэн бодол зарим хүнд байна.

Монголын зарим боловсруулагчдад зээлийн бэрхшээл байгааг олон хүн ярьж байв. Ноолуур худалдан авах улирлын үеэр богино хугацааны зээл авахад хүндрэлтэй байдаг байна. Боловсруулалтын анхан шатны ажиллагааг орон нутагт хийж, байнгын боловсруулах үйлдвэрийг ноолуур үйлдвэрлэгч бүсэд нь байгуулах бололцоотой гэж зарим хүн ярьж байлаа.

Дэлхийн ноолуурын зах зээлийн хялбар загвар

